

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 13.340, 13.100

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хамгаалах хэрэгсэл. Ерөнхий шаардлага, ангилал	MNS 4931 : 20XX
Occupational safety and health. Protective equipment. General requirement, classification	MNS 12.4.001 : 85-ын оронд

Стандарт, хэмжил зүйн газрын даргын ... оны ... дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар тушаалаар батлав.

Энэ стандарт нь ... оны дугаар сарын ... -ны өдрөөс эхлэн хүчинтэй.

1 Хамрах хүрээ

Энэ стандарт нь ажлын байрны аюултай хүчин зүйлийн нөлөөллөөс хүнийг хамгаалах буюу түүний нөлөөллийг бууруулах зориулалтаар хэрэглэх хамгаалах хэрэгслүүдэд хамаарна.

2 Нэр томьёо, тодорхойлолт

2.1

нийтийн хамгаалах хэрэгсэл

Ажлын байр, талбайг бүхэлд нь үйлдвэрлэлийн тохиромжгүй хүчин зүйлүүдээс хамгаалах зориулалтаар хэрэглэж байгаа техник технологийн хэрэгсэл

2.2

тусгай хамгаалах хэрэгсэл

Хувь хүн, тодорхой эрхтэн системийг үйлдвэрлэлийн тохиромжгүй хүчин зүйлээс хамгаалах зориулалтаар хэрэглэж байгаа ажлын тусгай хувцас, хэрэгслийг тусгай хамгаалах хэрэгсэл гэнэ.

2.3

хувийн хамгаалах хэрэгсэл

Хөдөлмөрлөх явцад ажлын байрны аюултай хүчин зүйлийн нөлөөллөөс хүнийг хамгаалах зориулалт бүхий хэрэгсэл.

2.4

ажлын тусгай хувцас

Ажлын байрны аюултай хүчин зүйлийн нөлөөллөөс ажилтныг хамгаалах зориулалт бүхий хувцас, гутал, малгай, бээлий зэрэг хэрэгсэл.

2.5

ажлын байрны аюултай хүчин зүйл

Хүний амь нас, эрүүл мэнд, хөдөлмөрлөх чадварт сөргөөр нөлөөлж ажил,

хөдөлмөртэй холбоотой гэмтэл бэртэл, өвчин үүсгэх уршиг бүхий ажлын байрны хүчин зүйл

3 Хамгаалах хэрэгслийн ангилал

3.1 Хамгаалах хэрэгслийг хэрэглэж байгаа байдлаар нь:

1. Нийтийн хамгаалах хэрэгсэл
2. Тусгай хамгаалах хэрэгсэл

3.1.1 Нийтийн хамгаалах хэрэгслийг зориулалтаас нь хамааран дараах байдлаар ангилна.

1. Ажлын байр болон үйлдвэрлэлийн орчны агаар, бичил цаг уурыг хэвийн байлгах хэрэгсэл
2. Ионжуулсан цацрагаас хамгаалах хэрэгсэл
3. Хэт улаан туяанаас хамгаалах хэрэгсэл
4. Хэт ягаан туяанаас хамгаалах хэрэгсэл
5. Цахилгаан соронзон цацрагаас хамгаалах хэрэгсэл
6. Цахилгаан болон соронзон орноос хамгаалах хэрэгсэл
7. Лазерын цацрагаас хамгаалах хэрэгсэл
8. Цахилгаан гүйдэлд нэрвэгдэхээс хамгаалах хэрэгсэл
9. Статик цахилгаан цэнэгээс хамгаалах хэрэгсэл
10. Орчны өндөр ба нам температураас хамгаалах хэрэгсэл
11. Механик хүчин зүйлийн үйлчлэлээс хамгаалах хэрэгсэл

3.1.2 Тусгай хамгаалах хэрэгслийг эрхтэн системийг хамгаалах байдлаар нь дараах ангид хуваана

3.1.2.1 Хувийн хамгаалах хэрэгсэл.

1. Толгой хамгаалах хэрэгсэл
2. Нүүр хамгаалах хэрэгсэл
3. Нүд хамгаалах хэрэгсэл
4. Амьсгал хамгаалах хэрэгсэл
5. Сонсгол хамгаалах хэрэгсэл
6. Арьс хамгаалах хэрэгсэл
7. Өндрөөс унахаас хамгаалах хэрэгсэл
8. Хөл хамгаалах хэрэгсэл
9. Гар хамгаалах хэрэгсэл
10. Эрхтэн тус бүрийг тусгаарлан хамгаалах хэрэгслүүд

3.1.2.2 Ажлын тусгай хувцас хэрэгсэл

1. Ажлын тусгай хувцас
2. Ажлын тусгай гутал
3. Малгай
4. Ажлын бээлий

4 Ерөнхий зүйл

4.1 Зорилго

Энэ стандартын зорилго нь хөдөлмөрлөх явцад ажлын байрны аюултай хүчин зүйлийн нөлөөллөөс ажилтныг хамгаалах, түүний сөрөг нөлөөллийг бууруулах зориулалтаар хэрэглэх нийтийн, хувийн хамгаалах хэрэгсэл болон ажлын тусгай хувцаст тавигдах ерөнхий шаардлагыг тогтооход чиглэнэ.

4.2 Хамгаалах хэрэгслийн ерөнхий шаардлага

1. Ажил олгогч нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үндэсний болон олон улсын байгууллагаар баталгаажсан хамгаалах хэрэгслийг сонгож хэрэглэнэ.
2. Импортоор оруулж ирсэн шинэ хамгаалах хэрэгслийг мэргэжлийн байгууллагаар шалгуулж зөвшөөрөл авсан байна.
3. Хамгаалах хэрэгсэл бүр баталсан норматив-техникийн баримт бичигтэй байна.
4. Баталсан норматив-техникийн баримт бичиггүй хамгаалах хэрэгслийг хэрэглэхийг хориглоно.
5. Хамгаалах хэрэгсэл нь хөдөлмөрийн үйл ажиллагааны явцад, хүний бие махбодод нөлөөлөх орчны нөлөөллийг тохиромжтой болгож, хөдөлмөрийн хэвийн нөхцөлөөр хангасан байх шаардлагатай.
6. Барилга төлөвлөлтийн арга хэмжээ, тоног төхөөрөмжийн хийц, үйлдвэрлэлийн үйл явцын зохион байгуулалт болон нийтийн хамгаалах хэрэгслээр хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангагдахгүй байгаа тохиолдолд тусгай хамгаалах хэрэгслийг хэрэглэнэ.
7. Хамгаалах хэрэгсэл нь ажлын байранд аюултай хүчин зүйлийг үүсгэдэггүй байна.
8. Хамгаалах хэрэгслийг тухайн ажил, технологийн процессын аюултай хүчин зүйлийг харгалзан үзсэний үндсэн дээр сонгоно.
9. Хамгаалах хэрэгсэл нь хамгаалах чадвар сайтай, хэрэглэхэд тохиромжтой байна.
10. Үйлдвэрлэлийн аюултай хүчин зүйлийг бууруулах, хамгаалах шаардлагыг хангасан байна.
11. Хамгаалах хэрэгслийн ерөнхий болон тусгай шаардлагын биелэлтэд ажил олгогч хяналт тавьж байх үүрэгтэй.

4.3 Хамгаалах хэрэгслийн тусгай шаардлага

4.3.1 Нийтийн хамгаалах хэрэгслийн тусгай шаардлага

1. Урт хугацаанд олон хүн ашиглах боломжтой, механик ачаалал даах чадвартай байна.
2. Нийтийн хамгаалах хэрэгсэл нь хувийн хамгаалах хэрэгсэлтэй хамт хэрэглэхэд нийцтэй байна.

3. Ажлын байрны зохион байгуулалтад саад болохгүй зөв төлөвлөж хийсэн байна.
4. Нийтийн хамгаалах хэрэгсэл нь байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байна.
5. Хамгаалах хэрэгсэлд техникийн үзлэг шалгалтыг тогтмол хийдэг байна.

4.3.2 Тусгай хамгаалах хэрэгслийн тусгай шаардлага

1. Хамгаалах хэрэгсэл нь техникийн, гоо зүйн болон эргономикийн шаардлагатай тохирч байна.
2. Тусгай хамгаалах хэрэгсэл нь ашиглалт, эрүүл ахуй, физиологи, хамгаалалтын үнэлгээг үнэлсэн үзүүлэлт, ашиглалтын заавартай байна.
3. Тусгай хамгаалах хэрэгслийг зориулалт, эдэлгээний хугацаа, ашиглах болон хадгалах зааврын дагуу хэрэглэнэ.

ТӨГСӨВ.

А хавсралт
(мэдээллийн)

Үйлдвэрлэлийн аюултай хүчин зүйлүүдээс хамгаалах нийтийн хамгаалах хэрэгсэл

№	Нийтийн хамгаалах хэрэгсэл	Хаалт	Автомат хяналт дохиолол	Хамгаалалт	Алсын удирдлага	Зогсоох төхөөрөмж	Аюулгүй байдлын тэмдгүүд	Шуугиан тусгаарлагч	Шуугиан намсгагч	Дулаан тусгаарлагч	Халуун хүйтний тархалтын төхөөрөмж	Халхлах төхөөрөмж	Газардуулга, тэг холболт	Тусгаарлах төхөөрөмжүүд хучлага бүрхүүл	Барометр /Норм байлгах/	Агааржуулагч, агаар цэвэрлэгч	Агаарын кондиционер	Халаалга	Битүүмэлэх төхөөрөмж	Изотопыг тээвэрлэгч, хадгалагч	Автоматаар салгах төхөөрөмж	Потенциалыг тэнцүүлэх хүчдэлийг бууруулах төхөөрөмж	Гал хамгаалагч	Аянга зйлуулагч	Агаар чийглэх төхөөрөмж	Цахилгаанжилтын эсрэг хүчилт	Статик цэнэг арилгагч	Хорт бодисыг зайлуулах төхөөрөмж	Ариутгал халдваргүйтэл хортон мэрэгч шавж устгах төхөөрөмж
1	Механик нөлөөнөөс	+	+	+	+	+	+																						
2	Дуу шуугианаас		+		+		+	+																					
3	Хэт өндөр дуунаас	+	+		+			+																					
4	Орчны хал, хүйтнээс	+	+		+				+	+																			
5	Лазер цацрагаас						+					+																	
6	Цахилгаан ба сор.орон						+					+	+	+															
7	Бичил цаг уураас	+										+			+	+	+	+											
8	Оптик квантын үүсгүүр	+		+																									
9	Ионжуулагч цацрагаас		+		+		+					+		+		+			+	+									
10	Цах,сор, цацрагаас		+		+		+					+		+															
11	Хэт улаан туяанаас	+		+		+										+													
12	Хэт ягаан туяанаас	+		+		+			+							+			+										
13	Цахилгаан гүйдлээс			+		+						+	+	+							+	+	+	+					
14	Цах.статик.цэнэгээс																								+	+	+		
15	Химийн хүчин зүйл	+	+		+		+									+												+	
16	Биологийн хүчин зүйл	+				+										+													+

В хавсралт
(мэдээллийн)

Үйлдвэрлэлийн аюултай хүчин зүйлүүдээс хамгаалах тусгай хамгаалах хэрэгсэл

№	Хувийн хамгаалах хэрэгсэл	Нүүр хамгаалах хэрэгсэл	Нүд хамгаалах хэрэгсэл	Амьсгал хамгаалах хэрэгсэл	Сонсгол хамгаалах хэрэгсэл	Арьс хамгаалах хэрэгсэл	Өндрөөс унахаас хамгаалах	Эрхтэн тус бүрийг тусгаарлан	Хөл хамгаалах хэрэгсэл	Толгой хамгаалах хэрэгсэл	Гар хамгаалах хэрэгсэл	Ажлын тусгай хувцас
1	Механик нөлөөнөөс						+		+	+	+	
2	Дуу шуугианаас				+							
3	Хэт өндөр дуунаас				+							+
4	Орчны халуун хүйтнээс										+	+
5	Лазер цацрагаас		+								+	+
6	Цахилгаан ба сор.орон											+
7	Бичил цаг уураас											+
8	Оптик квантын үүсгүүр											+
9	Ионжуулагч цацрагаас					+		+			+	+
10	Цах, сор, цацрагаас											+
11	Хэт улаан туяанаас		+			+					+	+
12	Хэт ягаан туяанаас		+			+					+	+
13	Цахилгаан гүйдлээс							+			+	+
14	Цах.статик.цэнэгээс										+	+
15	Химийн хүчин зүйл	+	+	+		+		+	+		+	+
16	Биологийн хүчин зүйл		+	+		+		+	+		+	+